



ДУНДГОВЬ АЙМГИЙН
САЙНЦАГААН СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2021 оны 12 сарын 30 өдөр

Дугаар А/235

Мандалговь

Тусгай зөвшөөрөл олгох тухай

Тамхины хяналтын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.7.14, 7 дугаар зүйлийн 7.3, Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.3, 16.3.4 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Тус сумын нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулдаг “Мөнх дэлгэрэх оюу” ХХК-ний Боржигоны 22-ын 1 тоот дахь хүнсний дэлгүүрт тамхи худалдан борлуулах тусгай зөвшөөрлийн эрхийг 2021 оны 12 дугаар сарын 30-ны өдрөөс 2023 оны 12 дугаар сарын 30-ны өдрийг хүртэл хугацаагаар олгосугай.

2. Утаат тамхи худалдан борлуулах үйл ажиллагаа эрхлэхдээ хууль, журамд заасан тавигдах шаардлагыг биелүүлж, үйл ажиллагаа явуулж буй объектынхоо эргэн тойрны 50 метр газрын цэвэрлэгээ болон хотын тохижилт, соёлжилтод онцгой анхааран, холбогдох хууль тогтоомжийн хүрээнд ажиллахыг иргэн (М.Цэрэнчунт)-д үүрэг болгосугай.

3. Дээрх захирамж гарсантай холбогдуулан 2020 оны 12 дугаар сарын 15-ны өдрийн “Жинд болор” ХХК-ний Болор хүнсний дэлгүүрт олгосон А/240 дүгээр захирамжийг хүчингүй болгосугай.

4. Энэ захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг худалдаа үйлчилгээ хариуцсан мэргэжилтэн (Э.Цэрэннадмид), Цагдаагийн хэсгийн байцаагч (М.Мөнхбат, Б.Хүслэн, Б.Батбаяр) нарт үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



С.БАТ-ОРГИЛ